



Хүнсний гол нэрийн барааны үнэ


2019 оны 6-р сарын 19-ний байдлаар

2019 оны 6-р сарын 19-ний байдлаар гол нэрийн барааны үнэ өмнөх сараас 3.9 хувь, өмнөх 7 хоногоос 0.1 хувиар өссөн байна.

Махны дундаж үнэ: 2019 оны 6-р сарын 19-ний байдлаар ямааны ястай махны үнэ өмнөх сараас 13.6 хувь, адууны ястай махны үнэ 11.9 хувь, үхрийн ястай махны үнэ 7.5 хувь, үхрийн цул махны үнэ 8.0 хувь, хонины ястай махны үнэ 7.2 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 0.3 хувиар өсч, бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ, төгрөг




2019 оны 6-р сарын 19-ний байдлаар 1 кг үхрийн цул мах 14229 төгрөг, үхрийн /ястай/ мах 11727 төгрөг, хонины /ястай/ мах дунджаар 10484 төгрөг, адууны /ястай/ мах 9071 төгрөг, ямааны /ястай/ мах 8800 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

Гурилын үнэ: 2019 оны 6-р сарын 19-ний байдлаар гурилын үнэ өмнөх сараас дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ 1.2 хувь, дээд зэргийн савласан гурилын үнэ 0.1 хувиар буурч, 1-р зэргийн савласан гурилын үнэ 3.7 хувь, 2-р зэргийн савласан гурилын үнэ 0.2 хувиар өсчээ. Өмнөх 7 хоногоос 2-р зэргийн савласан гурилын үнэ 0.1 хувиар өсч, бусад гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Будаа, элсэн чихрийн дундаж үнэ: 2019 оны 6-р сарын 19-ний байдлаар цагаан будааны үнэ өмнөх сараас 0.2 хувиар өсөж, өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Элсэн чихрийн үнэ өмнөх сараас 0.2 хувиар буурч, өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. (Зураг2).

Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, төмсний дундаж үнэ, төгрөг



Төмс, хүнсний ногооны дундаж үнэ: 2019 оны 6-р сарын 19-ний байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад байцааны үнэ 27.8 хувь, хүрэн манжингийн үнэ 26.5 хувь, луувангийн үнэ 8.4 хувь, сонгины үнэ 3.2 хувь, төмсний үнэ 1.9 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногоос хүрэн манжингийн үнэ 2.3 хувь, байцааны үнэ 1.2 хувь, лууван 0.5 хувиар буурч, төмсний үнэ 1.6 хувиар өссөн бол сонгины үнэ өөрчлөлтгүй байна.

Сүү, өндөг, ургамлын болон цэцгийн тосны дундаж үнэ: 2019 оны 6-р сарын 19-ний байдлаар өмнөх сараас задгай сүүний үнэ 8.5 хувь, савласан /1 литрийн/ сүүний үнэ 0.3 хувь, “элекстер” /0.5 литрийн/ сүүний үнэ 0.8 хувиар буурсан байна. Өмнөх 7 хоногоос бүх сүүний үнэ өөрчлөлтгүй байна.

Цэцгийн тосны үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна. Ургамлын тосны үнэ өмнөх сараас 0.1 хувиар өссөн бол өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй. Өндөгний үнэ өмнөх сар болон өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй байна.